



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

НЭР ДЭВШИГЧ НЬ ЗӨВХӨН РЕГИСТРИЙН ДУГААРАА БИЧИЖ ИРҮҮЛСЭН ХАНДИВЫГ БУЦААН ШИЛЖҮҮЛЭЭГҮЙ БОЛ ЗӨРЧЛИЙН ШИЙТГЭЛ ХҮЛЭЭНЭ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2025/0093

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Шийдвэрийн төрөл: Хариуцагчийн гомдлын шаардлагыг хангаж, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Баянгол дүүргийн Татварын хэлтсийн улсын байцаагчаас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн шийтгэлийн хуудсаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшсэн иргэнийг Зөрчлийн тухай хууль (2017)²-ийн 17.1 дүгээр зүйлийн 21³-д заасны дагуу хуульд заасан шаардлага хангаагүй хандивыг хандивлагчид буцаан илгээгээгүй гэх үндэслэлээр 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгосон байна.

Гомдол гаргагч нь энэхүү шийдвэрийг үл зөвшөөрч "... нэр хаяггүй гэх хандивын орлого нь нэр хаяг нь тодорхой бөгөөд хандивлагч нь өөрийн регистрийн дугаараа бичиж, хандив шилжүүлсэн байдаг. Тухайн иргэний регистрийн дугаар нь тухайн хүний нэр хаяг, мэдээллийг бүрэн илэрхийлэх бөгөөд регистрийн дугаараар нь хайж үзэхэд тухайн хандивлагчийн нэр, хаяг маш тодорхой харагдаж байгаа" гэж маргажээ.

Харин хариуцагчаас "гомдол гаргагч нь хуульд заасан шаардлага хангаагүй хандивын орлогыг хандивлагчид буцаан шилжүүлээгүй, буцах хаяг тодорхойгүй

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3431?daterange=2025-01-01%20-%202026-01-05&id=3&court_cat=3&bb=1.

² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, №24.

³ Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 21 дэх заалт "Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлэх, зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."



хандивыг улсын орлого болгоогүй гэх зөрчил гаргасан учраас шийтгэл оногдуулсан” гэж тус тус маргадаг.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүхээс:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)⁴-ийн 54 дүгээр зүйлийн 54.4⁵-т заасны дагуу хандивлагчдын хандивын шилжүүлгүүдийн гүйлгээний утгад Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т заасан мэдээлэл /нэр бичээгүй, нэрээ бичсэн боловч ялгагдах бүртгэлийн дугаар, хандивын эх үүсвэр, ядаж утасны дугаар бичээгүй/-ийг бүрэн тусгаагүй байхад нэр дэвшигчээс хандивыг буцаан шилжүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй гэж үзэх үндэслэлтэй байна гэж дүгнэсэн. Тухайн үндэслэлээр Баянгол дүүргийн татварын улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай гомдол гаргагчийн гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.
2. **Давж заалдах шатны шүүхээс:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т зааснаар мөнгөн хандивыг хандив өгч байгаа иргэний хувьд нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээдийн хувьд нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгасан байх шаардлагыг зохицуулсан байх боловч гомдол гаргагчийн тухайд хариуцлага хүлээлгэх хэмжээний зөрчил гаргаагүй байна гэж дүгнэсэн. Учир нь Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-ийг үгийн шууд утгаар тайлбарлавал иргэний хувьд нэр, иргэний бүртгэлийн дугаарыг банкны гүйлгээний баримтад тусгахаар, харин хандивын эх үүсвэрийг заавал тусгасан байхыг шаардаагүй бөгөөд “эх үүсвэрээ бичээгүй” гэх үндэслэлээр тухайн хандивыг буцаах үүргийг хүлээхгүй гэж дүгнэжээ. Тухайн үндэслэлээр Баянгол дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай гомдол гаргагчийн гомдлыг бүхэлд нь хангаж, гомдол гаргагчийн давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэжээ.
3. **Хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:** Гомдол гаргагч талын дан ганц “Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаасан буюу улсын орлого болгосон тухай тайлан”-г үндэслэн дүгнэсэн нь хэрэгт хамааралтай, нотлох баримтыг бүрэн гүйцэт, зөв үнэлээгүй ба гомдол гаргагч талын сонгуулийн дансны хуулгад төрийн санд шилжүүлсэн гүйлгээ, баримт байхгүй байгааг анзаараагүй, нотлох баримтыг тал бүрээс нь шинжлэн судлаагүй, нэг талыг баримталж, хуульд заасан үүргээ биелүүлэхгүй байх

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №49.

⁵ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх заалт “Хандив өгч байгаа иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ.”



боломж олгосон нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд нийцэхгүй байна.

4. **Хяналтын шатны шүүхээс:** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5⁶ дахь зохицуулалтын дагуу сонгуульд нэр дэвшигчид буюу хандив хүлээн авагч нь **мөнгөн хандив хүлээн авах тохиолдолд 1) иргэний нэр, иргэний бүртгэлийн дугаар; 2) хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар; 3) хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллүүд банкны гүйлгээний баримтад тусгагдаагүй бол хандивыг буцаан шилжүүлэх, мөн хандивыг буцаан шилжүүлэхэд буцах хаяг нь тодорхойгүй бол хандивыг улсын орлого буюу төрийн санд шилжүүлэх журмыг тодорхой зохицуулжээ.** (13)⁷
5. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогчоос “иргэний нэр, иргэний улсын бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн мэдээлэл”-ийг нэг бүрчлэн банкны баримтад заавал тусгах талаар “болон” гэдэг холбоосоор хоёрдмол утгагүй заасан. Хэрэв уг мэдээллүүд дутуу бол хуульд заасан шаардлага хангаагүй хандивт хамаарах бөгөөд **сонгуульд нэр дэвшигч нь тухайн орлогыг хандивлагчид буцаан шилжүүлэх, мөн буцах хаяг нь тодорхойгүй хандивыг улсын орлогод шилжүүлэх** үүргийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д зааснаар хүлээнэ. (14)
6. Давж заалдах шатны шүүх “... Монгол Улсын иргэний төрсөн он, сар, өдөр, хүйсийн талаарх мэдээллийг тусгасан 2 үсэг, 8 орон тоо бүхий тооноос бүрдсэн, үл давхардах нийлмэл код буюу **регистрийн дугаар бичсэн хандиваар тухайн этгээдийг хэн гэдгийг тодорхойлох бүрэн боломжтой, иймд тухайн гүйлгээг дан ганц нэр бичээгүй гэх үндэслэлээр шаардлага хангаагүй хандив гэж үзэхгүй ... эх үүсвэрээ бичээгүй гэсэн үндэслэлээр тухайн хандивыг буцаах үүргийг хүлээхгүй ...**” гэж дүгнэсэн нь **буруу**, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг буруу тайлбарлан хэрэглэжээ. (16)
7. Дээрх үндэслэлүүдээр Баянгол дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагчийн шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай гомдол гаргагчийн гомдлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн байна.

---o0o---

⁶ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалт “**Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.**”

⁷ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.